Тус байгууллагын мөрдөж байгаа бодлогын баримт бичгийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/22 дугаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн батлах тухай” тушаалаар баталж мөрдсөн байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Боловсролын яам, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Бүрэнтогтох сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 507,746.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	305,970.4	361,683.0	55,712.5
Урьчилж гарсан зардал	0.0	0.0	0.0
Бараа материал	366,719.6	448,322.6	81,903.0
Үндсэн хөрөнгө	6,177,680.2	6,534,259.8	356,579.6
Нийт хөрөнгө	6,878,768.9	7,386,515.4	507,746.5
Өр төлбөр	0.00	207,689.5	207,689.5
Засгийн газрын хувь оролцоо	2,298,239.4	2,298,239.4	-
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,298,239.4	2,298,239.4	-
Өмч: - төрийн	2,298,239.4	2,298,239.4	-
Хуримтлагдсан үр дүн	4,067,204.6	4,370,683.7	
Өмнөх үеийн үр дүн	3,529,453.0	4,067,204.	-
Тайлант үеийн үр дүн	-	300,056.9	346,855.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	513,439.4	509,902.7	3,536.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,878,768.9	7,386,515.4	507,746.5

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна. Тайланд онд үндсэн хөрөнгө, бараа материал, өр төлбөр дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө данс өмнөх оноос 55,712.5 мянган төгрөгөөр өссөн байна.
2. Бараа материалын дансны үлдэгдэл 81,903.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь БШУЯ-аас улсын төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй шилжиж ирсэн ном сурах бичиг, технологийн хичээлийн багаж хэрэгсэл, 20,626.6 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 54,013.8 мянган төгрөгийн хангамжийн материал хүлээн авсантай холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 356,579.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БШУЯ-аас 7,993.9 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүй хүлээн авсан, 320 хүүхдийн суудал бүхий хичээлийн байранд 123,613.9 мянган төгрөгийн сайжруулалт хийсэн, Төсвийн хөрөнгөөр 254,991.0 мянган төгрөгийн цахим анги орлогод авсан, Төсвийн хөрөнгөөр 61,030.2 мянган төгрөгийн утасны интернэтийн төхөөрөмж орлогод авсантай холбоотой байна.

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 31,428.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгөд 11,358.9 мянган төгрөгөөр дахин үнэ тогтоосон байна. Аймгийн ИТХ, Мөрөн сумын ИТХ-ын шийдвэр гаргуулж 70,591.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан байна.

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн тооллогын 2024 оны жилийн эцсийн тооллогоор нийт хөрөнгийг санхүүгийн тайланд туссан дүнгээс 229,783.6 мянган төгрөгөөр дутуу тоолсныг аудитын явцад зөрчлийг арилгасан.

4. Өр төлбөр 207,689.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Монголын цахилгаан холбоо ТӨХК-аас интернэтийн дотоод сүлжээ холбуулсан, Мэксим консалтинг ХХК-аас цахим кабенитын тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой өр үүссэн байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд орон нутгийн төсөв 740,280.0 мянган төгрөгөөр, улсын төсвөөс 4,749,874.4 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр тус тус төлөвлөж дээд шатны байгууллагад төсвийн санал хүргүүлсэн байна.

Уг төсвийн саналыг 32,000.0 мянган төгрөгөөр буруулж орон нутгийн төсвийг 708,280.0 мянган төгрөгөөр Мөрөн сумын ИТХ-ын тогтоолоор, улсын төсвийг 642,350.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 5,392,224.6 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийг нэмж баталсан шалтгаан хувьсах зардлын норматив нэмэгдсэн болон нөхөн хангалтын зардал, цалингийн өсөлт зэргээс хамаарсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 15 арга хэмжээг улсын төсвөөс 6,479,843.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 740,280.0 мянган төгрөг нийт 7,220,123.5 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,843,943.3 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байна. Орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 24,862.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, улсын төсвөөс авсан санхүүжилтээс 361,683.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Улсын төсвөөс санхүүжих					
71802	Ерөнхий боловсрол				
Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	14,830.4	14,830.4	-	100.0
80233	Хүүхэд хамгаалал	14,147.4	13,937.4	210.0	98.5
80312	Сургалт семинар	9,886.9	9,886.0	0.9	100.0
81605	Эрүүл мэндийг дэмжих	17,751.5	17,378.2	373.3	97.9
81801	Хүүхдийн үдийн /цай/ хоолны зардал	318,669.6	287,005.6	31,664.0	90.1
81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	149,258.6	149,258.6	-	100.0
81823	Боловсролын байгууллагын багш,	47,451.5	37,830.0	9,621.5	79.7
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө	5,169,299.0	4,913,133.3	256,165.7	95.0
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	546,793.6	537,758.2	9,035.4	98.4
81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	116,428.8	87,823.8	28,605.0	
81848	Сурах бичгийн тїрээс	23,370.5	21,893.4	1,477.1	93.7
81875	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	28,402.8	14,238.4	14,164.4	50.1
83602	ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	6,052.5	60,525.0	-	100.0
83603	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	17,500.4	17,500.4	-	100.0
	<b>ДҮН</b>	<b>6,479,843.5</b>	<b>6,182,526.3</b>	<b>361,683.0</b>	
	Орон нутгийн төсвөөс санхүүжих				
71802	Ерөнхий боловсрол				
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	740,280.0	715,417.1	24,862.0	96.6

Тайлант оны төсвийн зарцуулалтай холбоотой дараах зөрчил аудитаар илэрсэн. Үүнд:

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас 652.1 мянган төгрөгийг төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчин ажил олгогчийн НДШ-ээс даатгуулагчийн НДШ төлсөн. Энэ нь Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах заавар"

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлэх

Илрүүлэлт:

Ур чадварын нэмэгдлийг холбогдох журмын дагуу багш нарын ур чадварыг үнэлэх ажлын хэсэг байгуулж, ажлыг үнэлсэн баримтгүйгээр төсөв захирагчийн 5 удаагийн тушаалаар 142 багш, ажилтанд нийт 112,603.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл хөлс олгосон байна. Энэ нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын "Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай" 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/85, А/10/9 дүгээр хамтарсан тушаал

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Илрүүлэлт:

Тайланд жилд тус сургууль нь Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих нийт 183 мэдээллээс 177 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 6 мэдээлэл оруулах хугацаа болоогүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д "Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна"

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлэх

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн 100172215401 тоот дансаар ямар нэгэн гүйлгээ хийгдээгүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэн үр дүн

2024 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

#### 1.5.5 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Тус сургууль нь Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг болох Худалдан авсан бараа ажил үйлчилгээний гүйцэтгэлийг Төсвийн тухай хуулийн 54.5.3-д заасны дагуу гаргаж тайлагнаагүй байна. Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, 5 саяас дээших худалдан авалтын мэдээллийг татаж хянахад дараах байдалтай байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл	Арга	Батлагдсан төсөвт өртөг /мян. төг/	Гэрээний дүн
1	Гэрэл цахилгааны зардал	ГШБ	28,000.0	28,000.0
2	Түлш халаалтын зардал	ГШБ	625,280.0	625,280.0
3	Цэвэр бохир усны зардал	ГШБ	52,000.0	52,000.0
4	Урсгал засварын зардал	ШХА	35,000.0	20,000.0
5	Бусад зардал Байр ашиглалтын үйлчилгээний зардал	ШХА	14,830.4	14,830.4
6	Бусад зардал Сургалт семинар	ШХА	9,886.9	9,886.9
7	Бусад зардал Эрүүл мэндийг дэмжих	ШХА	14,830.4	14,830.4
8	Бусад зардал Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	Ерөнхий гэрээ	44,491.0	37,830.0
9	Бараа үйлчилгээний бусад зардал	ХА	76,638.9	70,100.0
10	Мэдээлэл технологийн үйлчилгээ	Ерөнхий гэрээ	108,755.8	70,169.6
11	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	ХА	59,321.4	59,321.4
12	Үдийн цай хөтөлбөр /хоолны материал/	НТШ	290,317.5	287,005.5
13	Бараа үйлчилгээний бусад зардал /нөхөн хангалт/	Ерөнхий гэрээ	146,600.0	146,600.0
14	Бараа үйлчилгээний бусад зардал / менежмент 35%/	ХА	69,208.2	69,208.2
15	Хүүхэд хамгаалал	ШХА	14,830.4	14,830.4
	<b>Дүн</b>		<b>1,589,990.9</b>	<b>1,519,892.8</b>

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан эсэхэд хяналт хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт:

Худалдан авалтын гэрээнд заасан нэр төрөл, тоо хэмжээгээр нийлүүлэлт хийгээгүй байна. Тухайлбал: "Мөрөнбуян ундрах" ХХК, "Хөвсгөл тэвхэн" ХХК-тай тус тус хүнсний бараа

бүтээгдэхүүн худалдан авах тухай гэрээ байгуулж, хүлээн авсан нэр төрөл, тоо хэмжээнээс илүү, дутуу нийлүүлсэн, нэмж гэрээгүй худалдан авалт хийсэн зөрчил илэрч байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-д “худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Аудитын шийдвэрлэлт:

Зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### **3.6 Ерөнхий чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн судалгааны үр дүн:**

#### **3.6.1 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд тус байгууллага нь 15 нэр төрлийн 1,519,892.80 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой хэсгийг тайлангийн 3.5.5 дахь хэсэгт тодруулсан болно.

#### **3.6.2 Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал**

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлын данснаас тайлант хугацаанд 1 хөтөлбөр, 3 арга хэмжээний хүрээнд 26,665.4 мянган төгрөгийн 21 ажил, гүйлгээ бүртгэж, санхүүжүүлсэн байна. Аудитаар дээрх зардлын гүйлгээнүүдийг хянаж үзэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### **3.6.3 Бараа үйлчилгээний бусад зардал**

Бараа үйлчилгээний бусад зардлын дансанд 204 ажил гүйлгээгээр нийт 466,284.7 мянган төгрөгийг зарцуулсан ба анхан шатны баримтаар нотлогдож байна.

#### **3.6.4 Байгууллагын бүтэц орон тоо**

Тус сургууль нь 2024 онд 174 орон тоо батлагдсан ба гүйцэтгэлээр удирдах 1, гүйцэтгэх 137, үйлчилгээний 36, нийт 174 орон тоогоор ажилласан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Дэлгэрмөрөн сургууль 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Хаан Соёмбо Аудит” ХХК-ийн аудитор Л.Оюунчимэг гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг аудитор С.Гансүх, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэнтогтох сумын ЕБС-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны 3-р улирлын Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,702,952.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 235,147.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 188,118.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд тус байгууллагын 2024 оны үйл ажиллагаатай холбоотой санхүүжилтийн эх үүсвэр болон зарцуулалтад материаллаг хэмнээний өөрчлөлт орсон тул тайлант оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлтэд харгалзан дараах байдлаар материаллаг түвшинг шинэчлэн тогтоов.

2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 6,812,155.4 мянган төгрөгийг суурь үзүүлэлтээр сонгож, хувь хэмжээг 2 хувиар тооцож, 340,607.8 мянган төгрөгөөр материаллаг түвшинг тогтоов.

#### **4.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 31 асуудлаар хяналтыг сорилыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллагын шилэн дансны цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн хяналт хэрэгжүүллээ. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл

Тайланд жилд тус сургууль нь Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих нийт 183 мэдээллээс 178 мэдээллийг хугацаандаа мэдээлж, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-хөтөлбөр зориулалт зэрэг 1 мэдээллийг дутуу мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д "Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ерөнхий боловсролын Дэлгэрмөрөн сургуулийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар худалдан авах ажиллагаа, шилэн данс, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 4 зөрчил илэрсэн ба аудитын явцад Цахилгаан эрчим хүчний төлбөрийг хугацаандаа төлөөгүйгээс гэрэл цахилгааны зардлаас алданги төлсөн зөрчил 439.6 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар орон нутгийн төсвийн дансанд төлүүлж 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 67,341.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 1 албан шаардлага тогтоосон байна. Үүнээс 67,341.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 1 албан шаардлага бүрэн хэрэгжиж 100 хувийн хэрэгжилттэй байна. Тус сургуулийн үндсэн хөрөнгийн данс бүртгэлд бүртгэлтэй 19 нэр төрлийн нийт 40,345.8 мянган төгрөгийн эд хөрөнгийг актлуулахаар захирлын 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 376 дугаар албан бичгийг хүргүүлж, Мөрөн сумын ИТХ-ын даргын "Үндсэн хөрөнгө актлах болон үнийг шинэчлэн тогтоох, актлах санал уламжлах тухай" 2024 оны 69 дүгээр захирамжаар 11,358.9 мянган төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон бөгөөд Мөрөн сумын ИТХ 27,670.1 мянган төгрөгийн хөрөнгийн актлуулах саналыг аймгийн ИХТ-д уламжлаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг үнэ тогтоож ашиглалтын хугацааг тооцож ажиллах

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	50,000.0	1	50,000.00	100%
Зөвлөмж	3	17,341.9	3	17,341.9	100%
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>67,341.90</b>	<b>4</b>	<b>67,341.90</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. "Гэрэгэ эдик" ХХК-д түрээсийн номны орлого төвлөрүүлэх зорилготой пос автомашиныг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авсан нь нийлүүлэгч байгууллагын орлогыг төвлөрүүлж байгаа учир төсвийг зориулалт бусаар зарцуулсан тул авлага үүсгэхэд анхаарах асуудал гэж үзлээ.

2. Аймгийн боловсролын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн "Урамшуулал олгох тухай" А/85 дугаар тушаалаар захиралд 1 сарын цалинтай тэнцэх хэмжээгээр урамшуулал олгосон асуудлыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 26,563.8 мянган төгрөгийн зөрчил илэрч 5 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой алдаа илрээгүй байна.

5.2 Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага өгөөгүй болно.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### Илрүүлэлт-1:

Цалингийн зардлаас 652.1 мянган төгрөгийг төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчин ажил олгогчийн НДШ-ээс даатгуулагчийн НДШ төлсөн. Энэ нь Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал ашиглах

заавар"-ыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах

Илрүүлэлт-2:

Тус сургуулийн захирлын 2024 оны Б/55 дугаар тушаалаар байгууллагын нягтлан бодогчид 1 сар, няравт 0.5 сарын үндсэн цалингаар тус тус балансын урамшуулалд 1,992.0 мянган төгрөгийг төсвийн зарлагын эдийн ангилал зөрүүтэй зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасныг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Балансын урамшууллыг олгох талаар дотоод журамд зааж, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас олгож байх

Илрүүлэлт-3:

Худалдан авалтын гэрээнд заасан нэр төрөл, тоо хэмжээгээр нийлүүлэлт хийгээгүй байна. Тухайлбал: "Хөвсгөл тэвхэн" ХХК, "Мөрөнбуян ундрах" ХХК-тай тус тус хүнсний бараа бүтээгдэхүүн худалдан авах тухай гэрээ байгуулж, хүлээн авсан нэр төрөл, тоо хэмжээнээс илүү нийлүүлсэн, 23,480.0 мянган төгрөгийн гэрээгүй худалдан авалт хийсэн зөрчил илэрч байна. Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-д "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх"

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.7-д "худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх"

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажил олгогчийн НДШ-ийн зардлаас даатгуулагчийн НДШ төлсөн	1	652.1					1	652.1
Нягтлан бодогчид 1 сар, няравт 0.5 сараар тус тус тооцож балансын урамшуулал олгосон	1	1,992.0					1	1,992.0
Ур чадварын нэмэгдлийг холбогдох журмын дагуу багш нарын ур чадварыг үнэлэх ажлын хэсэг байгуулаагүй байна	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>2,644.1</b>					<b>3</b>	<b>2,644.1</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авалтын гэрээнд заасан хүлээн авсан нэр төрөл, тоо хэмжээнээс илүү нийлүүлсэн, гэрээгүй худалдан авалт хийсэн зөрчил илэрч байна.	1	23,919.7	1	439.7			1	23,480.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>23,919.7</b>	<b>1</b>	<b>439.7</b>			<b>1</b>	<b>23,480.0</b>
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>26,563.8</b>	<b>1</b>	<b>439.7</b>			<b>4</b>	<b>26,124.1</b>